



ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

(Эпидемиологийн 2 дугаар долоо хоног)


Нэг. Угаарын хийн хордлогын шалтгаант үйл явдлын мэдээ

- Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар 154 иргэн угаарын хийн хордлогод өртсөн. Үүнээс эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буцсан 119, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан 32, нас барсан 3 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хүснэгт 1. Угаарын хийн цочмог хордлогын тохиолдол, байршлаар

Үзүүлэлт		Хүний тоо
Угаарын хийн хордлогод өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандсан хүний тоо		154
Мэдээ ирүүлсэн эрүүл мэндийн байгууллага		
ХЯТҮТ-д хандсан		54
ЭХЭМҮТ-д хандсан		41
Нийслэлийн эрүүл мэндийн газар		39
Аймгийн ЭМГ, НЭ		20
Эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байдал		
Хэвтэн эмчлүүлсэн		32
Зөвлөгөө, эмчилгээ аваад буцсан		119
Нас барсан		3
Хүн ам зүйн байдал		
Хүйсээр:	Эрэгтэй	73
	Эмэгтэй	81
Насны ангиллаар:	Насанд хүрэгчид	92
	Хүүхэд /0-17/	62
Улаанбаатар хот:		Хороо/Хүний тоо
		26/131
Дүүргээр:	Сонгинохайрхан	7/35
	Баянзүрх	7/42
	Баянгол	2/6
	Сүхбаатар	2/5
	Чингэлтэй	5/27
	Хан-Уул	2/6
	Налайх	1/10
	Тодорхойгүй	0
Хөдөө орон нутаг:		Сум/Хүний тоо
		5/23
Аймгаар:	Баянөлгий аймаг	2/15
	Сэлэнгэ аймаг	1/5
	Өвөрхангай аймаг	1/1
	Төв аймаг	1/2


- 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 1 дүгээр сарын 11-ний өдрийн буюу 2 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын 75 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 6%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас 14%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Байршлаар авч үзвэл БЗД, СХД, ЧД-т зонхилон бүртгэгдсэн.



Зураг 1. Угаарын хийн хордлогын тохиолдол, долоо хоногоор

Хоёр. Химийн бодисын цочмог хордлогын мэдээ

- Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар 26 иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. Үүнээс эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буцсан 13, хэвтэн эмчлүүлсэн 13 тохиолдол бүртгэгдсэн байна.
- 2025 оны 2 дугаар долоо хоногт химийн цочмог хордлогод өртсөн 11 хүн (хүүхэд-2, насанд хүрэгчид-9) хандаж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. Өмнөх оны мөн үеэс 27%-иар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 31%-иар өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 2. Химийн хордлогын тохиолдол, долоо хоногоор

Хүснэгт 2. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (ХЯТҮТ, ЭХЭМҮТ)

№	Шалтгаан	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	4	9	13
2	Эмийн хордлого	11	2	13
Нийт		15	11	26

- Санаатай буюу амиа хорлох зорилгоор эм, химийн бодис ууж, хордлогод өртсөн 15 тохиолдол бүртгэгдсэн ба 19-өөс 56 насныхан байна.

ХОР СУДЛАЛ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА